



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/Ан

Булган сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Байгалийн ургамлыг хамгаалах, хөрсний доройтлоос сэргийлэх зорилгоор Сансар 1, 2-р садны тохижилт (Булган сум) ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга:

Д.Батцогт (Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Гишүүд:

Б.Баярцэнгэл (Худалдан авах ажиллагааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

М.Цэрэнчимэд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Иргэний төлөөлөл:

Б.Туяа (Булган сумын иргэн)

Нарийн бичгийн дарга:

Г.Дэлгэр (Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Д.Батцогт)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил-2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010182